



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараахь хаягаар харилцана уу:

Газрын захирал: С.Энхзаяа  
Утас: 261663

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512

Аудитор: С.Бат-Эрдэнэ  
Утас: 261628

Монгол Улсын Үндэсний Аудитын газар

Монгол Улс  
Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу  
Засгийн газрын IY байр  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

### АУДИТЫГ ДУУСВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

---

#### АГУУЛГА

---

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудитийн дуусвар болсон тухай  
тайлан

**Хавсралт 4:** Аудитлагдсан санхүүгийн тайлан

2014 оны 4 дүгээр сар

## **Оршил**

Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг тус газрын удирдлагад танилцуулж байна.

Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Улаанбаатар хотын Статистикийн газар болон 21 аймгийн Статистикийн 22 хэлтэс, ҮСХ-ны төв аппарат, нэмэлт санхүүжилт, Хүн амын тооллогын товчоо, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй Үндэсний Статистикийг сайжруулах “Монстат” төсөл зэрэг, нийт 25 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцад нэгтгэгдсэн 23 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийгдэж 20 байгууллага Зөрчилгүй санал дүгнэлт, Увс, Булган аймгийн Статистикийн хэлтэс, Хүн ам, орон сууцны тооллогын товчооны санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлтийг өгсөн байна.

Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголоор Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багц 8,915.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,669.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 17.0 сая, гадаадын зээл тусламжийн санхүүжилтээс 623.3 сая, нийт 8,309.6 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын зардалд 183.9 сая, урсгал үйл ажиллагааны зардалд 6,843.5 сая төгрөгийг зарцуулан 1,161.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн хуулиар батлагдсан төсвөөс нийт 1,766.9 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, гүйлгээ баланс зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн нэгтгэсэн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгөхийг зорилоо.

Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

### **Санхүүгийн дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа байгууллагын дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж

олгосон. Тухайн жилд асуудал үүсгэсэн эдгээр хяналтыг бид Үндэсний статистикийн хорооны даргын анхааралд хандуулж байна.Үүнд:

- Үндэсний Статистиктийн хорооны санхүү бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулсан НББ-ийн бодлогын баримт бичгийг 2003 онд баталсан боловч өнөөгийн мөрдөгдөж буй бүртгэлийн стандарт, Сангийн сайдын тушаалаар батлан гаргасан заавар, журамд нийцүүлэн шинэчилж өөрчлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Төсвийн тухай хуулийн 69.1-д "ТЕЗ бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах эрсдэлийн удирдлагаар хангасан дотоод аудитын албыг байгуулж дотоод аудитор ажиллуулна" гэж заасан боловч тус нэгжийг байгуулж, дотоод хяналтыг гүйцэтгээгүй байна.

### **Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Нэг. Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зарим асуудлын талаар.

#### **1.1 Бараа материалын талаар**

- Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс нь үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг бүрэн гаргалгүйгээр санхүүгийн тайланг бэлтгэж гаргасныг аудитаар залруулсан байна.Энэ нь НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 -д “батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах “гэж заасныг зөрчсөн байна.

#### **1.2 Авлага, өглөгийн талаар**

- Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 зүйлийн 9.1 дэхь заалтыг зөрчиж 0.4 сая төгрөгийн авлага, Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс 0.5 сая төгрөгийн

ХХОАТ-ын татварын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүйг аудитаар залруулсан байна.

### **1.3 Үндсэн хөрөнгийн талаар**

- Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалыг зөрчин Сүхбаатар, Хэнтий, Дундговь аймгийн Статистикийн хэлтсүүд Үндэсний Статистикийн хорооноос хэлтэс тус бүрт үнэ төлбөргүй шилжүүлсэн 1.1 сая төгрөгийн, Нийслэлийн статистикийн хэлтэс өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг засгийн газрын оруулсан капитал дансанд нэмэгдүүлж бүртгэснийг аудитаар залруулсан байна.
- Үр дүнгийн тайланд Дорнод аймгийн Статистикийн хэлтэс 2.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг, Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.7 сая төгрөгөөр дутуу тусгасныг аудитаар залруулсан байна.

### **1.4 Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар**

- Цалингийн зардлын хэмнэлтээс Завхан аймгийн Статистикийн хэлтэс 3.5 сая, Увс аймгийн Статистикийн хэлтэс 6.6 сая төгрөгийг, Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс судалгааны зардлаас урьд оны өглөг барагдуулахад 10.0 сая төгрөгийг төрийн сангийн зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.
- Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс ээлжийн амралтын цалинг 0.4 сая төгрөгөөр, Төв аймгийн Статистикийн хэлтэс үндэслэлгүйгээр 7.1 сая төгрөгийн цалинг тус тус илүү олгосон байна.
- Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 1.0 сая төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна.

### **1.5 Санхүүгийн тайлан тэнцлийн талаар**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн.

- Дорнод аймгийн Статистикийн хэлтэс 19.9 сая, Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтэс 47.0 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна.
- Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс үр дүнгийн тайланд 3.5 сая төгрөгийн орлогыг илүү, Булган аймгийн Статистикийн хэлтэс 64.2 сая төгрөгийн орлого, зардлыг дутуу, Дундговь аймгийн Статистикийн хэлтэс хөтөлбөр арга хэмжээний зардлын 52.5 сая төгрөгийн зарцуулалтыг дутуу, мөнгөн гүйлгээний тайланд Нийслэлийн Статистикийн газар 3.0 сая төгрөгийг дутуу тусгасныг аудитаар залруулсан байна.

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Өмнөговь аймгийн Стастикийн хэлтэс нэмэлт санхүүжилтээр авсан 60.0 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн Стастикийн хэлтэс 11.0 сая төгрөгийн орлого, зардлыг илүү тусгасныг аудитаар залруулсан байна.

Нийслэлийн Статистикийн газар болон 21 аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 339.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 323.8 сая төгрөгийн материаллаг зөрчлийг залруулан 16 зөвлөмжийг өгсөн байна.

**Хоёр. Үндэсний статистикийн хорооны даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аппарат, нэмэлт санхүүжилтийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зарим асуудлын талаар.**

УСНББОУС-01, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зарим үзүүлэлтүүдийг зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- MNGU701 төслийн хүрээнд НҮБ-ын хүн амын сангаас хандиваар олгосон 68.9 сая төгрөгийн өртөгтэй Land-200 автомашиныг ҮСХ-ы тайланд орлого аваагүй байна.
- ҮСХ-ы тайлангаас Увс аймгийн Статистикийн хэлтэст 1.9 төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхдээ үндсэн хөрөнгийн кредитээс эрдэм шинжилгээний зардалд бичилт хийсэн байна.
- ҮСХ-нь тайлант жил нийт 48.7 сая төгрөгийн бараа материалыг материалын тайланд орлого авалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан НББ-ийн дансны зааврыг зөрчин 103.5 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна. Тухайлбал: “Бид сольюшин” ХХК-аар “Хүн ам, өрхийн бүртгэлийн онлайн програм” хийлгэхээр гэрээ байгуулан 49.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч шууд зардлаар бүртгэсэн байна.

- НДС-аас авсан хөдөлмөрийн чадвараа түр алдасны болон жирэмсэн, амаржсан эхэд олгосон 46.5 сая төгрөгийн санхүүжилтийн дүнгээр үр дүнгийн нэгтгэсэн тайланд орлого, зардлаар бүртгэсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд төсвийн хувиарлагдаагүй зардлыг 7.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 276.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 222.6 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулж, 5 төрлийн зөвлөмж өглөө.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар салбарын хэмжээнд нийт 1 зөвлөмж өгсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Орон нутаг дахь салбаруудад нийт 21 зөвлөмж өгсөнөөс 86 хувь буюу 18 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн гэж үзэн **“Зөрчилгүй”** санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудитор санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 679

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН  
ХОРООНЫ ДАРГА С.МЭНДСАЙХАН  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үндэсний Статистикийн хорооны дарга Төсвийн тухай хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ~~УСНББОУС-д~~ нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

## 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### **Менежментийн захидал**

#### **Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс**

##### **Асуудал 1**

Бараа материал, түүхий эд

#### **Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс**

##### **Асуудал 2**

Дотоод хяналтын талаар

##### **Асуудал 3**

Нягтлан бодох бүртгэлийн талаар

#### **Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс**

##### **Асуудал 4**

Тайлан тэнцлийн талаар

##### **Асуудал 5**

Санхүүгийн аудитын дүгнэлтийн талаар



## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан байгууллагын удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

### ҮАГ-ын ажиглалт

1.ҮСХ-ны аппарат нь тайлант жилд нийт 48.7 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг материалын дансанд орлого авалгүйгээр мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бичиж хаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

### Эрсдэлүүд

Үр дүнгийн тайланд зардал буруу илэрхийлэгдэх, хөрөнгө материалын зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт сулрах;

### ҮАГ-ын зөвлөмжүүд

1.Бараа материалын орлого, зарлагыг данс бүртгэлд үнэн зөвөөр тайлагнах;

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

### Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### ҮАГ-ын ажиглалт

Төсвийн тухай хуулийн 69.1-д "ТЕЗ бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах эрсдэлийн удирдлагаар хангасан дотоод аудитын албыг байгуулж дотоод аудитор ажиллуулна" гэж заасан боловч тус нэгжийг байгуулж, дотоод аудиторыг томилоогүй байна.

### Эрсдэлүүд

Дотоод аудит байхгүйгээс санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавигдахгүй болох;

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуульд заасны дагуу дотоод аудитын алба, нэгжийг байгуулж ажиллуулах;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

### Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### ҮАГ-ын ажиглалт

ҮСХ-нь 2003 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа боловч энэ нь холбогдох хууль, эрх зүйн акт, тэдгээрийн өөрчлөлтүүд тусгагдаагүй мөн салбарын хэмжээгээр мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэснийг зөрчиж байна.

### Эрсдэлүүд

Салбарын хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогогүйгээс төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан зөрүүтэй нэгтгэгдэх;

### ҮАГ-ын зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагын дагуу бүртгэлийн бичиг баримтыг шинэчилж боловсруулан, салбарын хэмжээнд мөрдөж ажиллах;

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

### Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### ҮАГ-ын ажиглалт

1. ҮСХ-ы төв аппарат нь мөнгөн хөрөнгийн данснаас нийт 103.5 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд хааж бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалт болон Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөөгүй байна.

#### Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд зардлын гүйцэтгэл үнэн зөвөөр илэрхийлэгдэхгүй байх, авлага, өглөг дутуу тусгагдах;

#### ҮАГ-ын зөвлөмжүүд

Харилцагч нэг бүрээр тооцооны данс үүсгэн өглөг, авлагын журналд ажил гүйлгээг бүрэн тусгаж байх;

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **ҮАГ-ын ажиглалт**

Орон нутагт дахь салбаруудын аудитаар 339.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 323.8 сая төгрөгийн материаллаг зөрчлийг залруулж, аудитаар нийт 16 зөвлөмж өгөгдсөн бөгөөд Увс, Булган аймгийн Статистикийн хэлтэс, Хүн ам, орон сууцны тооллогын товчооны санхүүгийн тайлан хязгаарлалттай, бусад нь зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 276.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 222.6 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулж, 5 төрлийн зөвлөмж өглөө.

### **Эрсдэлүүд**

ҮСХ-ны даргын төсвийн багцын нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй тайлан нэгтгэгдэх;

### **ҮАГ-ын зөвлөмжүүд**

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээг авах, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагуудын дарга, нягтлан бодогчдод холбогдох арга хэмжээг авч ҮАГ-т хариу ирүүлэх;

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>72,966,275.52</b>	<b>331,919,199.45</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө	7,379,664.00	17,347,115.46
Төгрөг\ ЖМС	7,379,664.00	17,347,115.46
Банкинд байгаа бэлэн мөнгө	65,586,611.52	314,572,083.99
Төгрөг		129,943,885.28
Төсөвт байгууллын харилцах (Төрийн сан)		63,929,065.12
Нэмэлт санхүүжилтийн харилцах		66,014,820.16
Гадаад валют	65,586,611.52	184,628,198.71
Бусад төсөл, нөөцийн харилцах	65,586,611.52	184,628,198.71
<b>АВЛАГА</b>	<b>5,744,002.00</b>	<b>5,806,298.66</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага		325,140.00
Бусад авлага	5,744,002.00	5,481,158.66
Байгууллагаас авах авлага	5,450,468.00	4,771,669.24
Бусад зардлын тооцооны авлага	5,450,468.00	4,771,669.24
Хувь хүмүүсээс авах авлага	293,534.00	709,489.42
<b>УРЬДЧИЛГАА</b>		<b>212,297,274.61</b>
Бусад урьдчилгаа		212,297,274.61
Урьдчилж гарсан зардал		212,297,274.61
Урьдчилж төлсөн зардал		212,297,274.61
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>131,368,832.88</b>	<b>363,203,754.23</b>
Хангамжийн материал	131,368,832.88	360,272,321.07
Бичиг хэргийн материал	38,098,915.29	188,616,826.29
Аж ахуйн материал	54,201,132.81	130,765,394.72
Сэлбэг хэрэгсэл	15,813,845.00	11,094,434.00
Түлш, шатах тослох материал	268,000.00	1,167,300.00
Бусад бараа материал	22,986,939.78	28,628,366.06
Бусад		2,931,433.16
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>210,079,110.40</b>	<b>913,226,526.95</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,425,873,926.15</b>	<b>1,531,615,845.42</b>
Биет хөрөнгө	1,364,906,992.33	1,487,032,376.52
Авто-тээврийн хэрэгсэл	203,142,122.01	254,028,600.93
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	294,864,297.00	398,053,497.00
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(91,722,174.99)	(144,024,896.07)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	863,927,587.34	912,771,820.01
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	2,204,049,903.53	2,487,603,933.89
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(1,340,122,316.19)	(1,574,832,113.88)
Тавилга, аж ахуйн эд хогшил	285,088,669.08	308,915,919.22
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	474,924,267.45	539,167,339.25

Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(189,835,598.37)	(230,251,420.03)
Бусад үндсэн хөрөнгө	12,748,613.90	11,316,036.36
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	13,803,318.00	13,803,318.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(1,054,704.10)	(2,487,281.64)
Биет бус хөрөнгө	60,966,933.82	44,583,468.90
Програм хангамж	60,966,933.82	44,583,468.90
Програм хангамж - Анхны өртөг	199,093,409.79	223,247,570.45
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(138,126,475.97)	(178,664,101.55)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,635,953,036.55</b>	<b>2,444,842,372.37</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,970,505.00	4,652,961.00
Өглөг	15,970,505.00	4,652,961.00
Ажилчидтай холбогдсон тооцоо	235,203.00	293,585.00
НДШ-ийн өглөг		293,585.00
ХАОАТ-ын өглөг	235,203.00	
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	5,441,768.00	
Бусад зардлын тооцоо	5,441,768.00	
Бусад өглөг	10,293,534.00	4,359,376.00
Байгууллагад төлөх өглөг	10,000,000.00	3,510,702.00
Хувь хүмүүст төлөх өглөг	293,534.00	848,674.00
Урьдчилж орсон орлого	1,000,000.00	
Төсөвт байгууллага	1,000,000.00	
Урьдчилж орсон орлого	1,000,000.00	
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	16,970,505.00	4,652,961.00
Засгийн газрын хувь оролцоо	1,618,982,531.55	2,440,189,411.37
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	2,317,089,248.17	2,009,560,117.88
Хуримтлагдсан үр дүн	(737,228,743.60)	403,306,708.51
Өмнөх үеийн үр дүн	(737,228,743.60)	(444,033,385.81)
Тайлант үеийн үр дүн		847,340,094.32
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	39,122,026.98	27,322,584.98
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,618,982,531.55	2,440,189,411.37
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,635,953,036.55</b>	<b>2,444,842,372.37</b>



## АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,198,986,149.58	10,189,683,580.99
Гадаад орнуудаас үзүүлсэн	1,725,624,396.56	964,596,269.30
Урсгал	1,725,624,396.56	623,273,606.79
Хөрөнгийн		341,322,662.51
Олон улсын байгууллагын тусламж	40,982,075.88	378,953,817.53
Урсгал тусламж		378,953,817.53
Хөрөнгийн тусламж	40,982,075.88	
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	6,432,379,677.14	8,846,133,494.16
Улсын төвлөрсөн төсвөөс	6,275,307,423.14	8,840,668,494.16
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,036,182,248.14	7,485,418,180.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	907,159,680.00	
Хөрөнгийн	331,965,495.00	183,858,278.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,171,392,036.16
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөнөөс		143,502,935.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,024,644,601.16
Төсвийн урамшуулал		3,244,500.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	157,072,254.00	5,465,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	157,072,254.00	
Хөрөнгийн		5,465,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	437,592,874.36	826,342,820.74
Бараа, үйлчилгээний борлуулалт	437,592,874.36	826,342,820.74
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	28,089,899.36	71,280,711.13
үндсэн бус үйл ажиллагааны орлого	28,089,899.36	18,019,321.51
үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		53,261,389.62
Захиргааны хураамж	409,502,975.00	755,062,109.61
Шүүхийн шийдвэрийн төлбөр	409,502,975.00	755,062,109.61
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,636,579,023.94</b>	<b>11,016,026,401.73</b>
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	2,724,172,203.75	3,148,131,049.05
үндсэн болон нэмэгдэл цалин	2,455,387,720.90	2,842,470,929.66
үндсэн цалин	1,619,960,155.01	2,414,080,016.26
Гэрээт ажилчдын цалин	561,100,402.89	
Бусад нэмэгдлүүд	274,327,163.00	428,390,913.40
үр дүнгийн урамшуулал	93,596,651.00	254,263,472.00
Унаа, болон бусад нөхөн олговор	180,730,512.00	174,127,441.40
Нийгмийн хамгааллын шимтгэл	268,784,482.85	305,660,119.39
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	224,755,547.40	252,601,425.45
Тэтгэврийн даатгалын шимтгэл	179,968,534.15	198,330,208.45

Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,616,938.85	20,804,608.89
үОМШ өвчний даатгалын шимтгэл	22,357,532.69	26,474,838.51
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	10,812,541.71	6,991,769.60
Эрүүл мэндийн даатгалын хураамж	44,028,935.45	53,058,693.94
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,516,065,104.12</b>	<b>5,686,085,757.97</b>
Бараа үйлчилгээний урсгал зардал	2,439,138,507.08	4,852,944,534.65
Бусад бараа үйлчилгээний зардал	2,439,138,507.08	4,852,944,534.65
Бичиг хэргийн зардал	34,494,662.00	47,299,980.90
Тээвэр, шатахуун	64,183,149.85	289,674,116.99
Шуудан, харилцаа холбоо	58,012,403.95	56,295,710.60
Дотоод албан томилолт	40,729,854.00	429,131,296.00
Гадаад албан томилолт	12,427,346.00	52,347,361.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	24,000.00	21,100.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		32,863,980.00
Сургалт семинарын зардал	24,464,965.00	21,241,441.00
Эрдэм шинжилгээний ажил хийх	1,431,385,958.00	2,451,324,800.41
Төлбөр хураамж, жижиг татварууд	227,176,866.20	747,467,059.98
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,800,000.00	82,142,530.34
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		73,651,710.00
ТӨГАҮ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод) \		6,490,820.34
ТӨГҮА \Эд хөрөнгийн даатгал\	2,000,000.00	
ТӨГҮА \Тээврийн хэрэгслийн даатгал\	800,000.00	2,000,000.00
Маягт хэвлүүлэх зардал	4,275,000.00	36,105,660.00
Урсгал засвар	7,513,207.00	12,912,022.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		
Гадаадын зочны зардал	16,273,758.00	4,043,805.00
Засварын зардал		113,891,100.00
үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	494,154,046.08	462,269,781.43
Аж ахуйн материал худалдан авах зардал	450,407.00	13,775,000.00
Бараа материал акталсны зардал	317,600.00	137,789.00
Улсын мэдээллийн маягтын зардал	20,455,284.00	
Хөтөлбөр арга хэмжээний зардал	3,076,926,597.04	833,141,223.32
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	1,765,705,710.04	30,658,510.00
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	8,806,500.00	27,414,010.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	1,677,339,533.24	
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	79,559,676.80	3,244,500.00
Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/		1,000,000.00
Бусад төсөл арга хэмжээ		1,000,000.00
Шагнал, тэтгэмжийн зардал		1,000,000.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	1,311,220,887.00	801,482,713.32
Бусад төсөл арга хэмжээ	1,311,220,887.00	801,482,713.32
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ</b>	<b>259,391,606.00</b>	
Хөрөнгө оруулалт	259,391,606.00	
Дотоод эх үүсвэрээс	259,391,606.00	
Төсвийн хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж	92,864,910.00	

Төсвийн хөрөнгө оруулалт их засвар	166,526,696.00	
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	477,180,824.97	1,175,965,121.20
Олон улсын байгууллагуудад	13,904,800.00	14,948,850.00
Олон улсын гишүүний татвар, хандив	13,904,800.00	14,948,850.00
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	463,276,024.97	1,161,016,271.20
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	463,276,024.97	1,161,016,271.20
Төвлөрүүлэх шилжүүлэг	463,276,024.97	1,161,016,271.20
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	172,925,502.00	152,159,859.00
Нийгмийн даатгалын зардал	146,882,394.00	127,106,968.00
Нийгмийн даатгалын зардал	146,882,394.00	127,106,968.00
өндөр настны тэтгэвэр	146,882,394.00	127,106,968.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	26,043,108.00	25,052,891.00
Мөнгөн хэлбэрээр	26,043,108.00	25,052,891.00
Нэг удаагийн тэтгэмж	26,043,108.00	25,052,891.00
БУСАД ЗАРДАЛ		1,600,000.00
Бусдын өмчийг ашигласны зардал		1,600,000.00
Байрны түрээс		1,600,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,149,735,240.84	10,163,941,787.22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(513,156,216.90)	852,084,614.51
Гадаад валютын ханшийн зөрүү, үнийн зөрүү		33,481,911.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		33,481,911.96
үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,257,960.39	38,226,432.15
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,257,960.39	38,226,432.15
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(520,414,177.29)	847,340,094.32

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,162,004,073.70	9,900,339,165.48
Гадаад орнуудаас үзүүлсэн	1,211,636,563.70	623,273,606.79
Урсгал	1,211,636,563.70	623,273,606.79
Олон улсын байгууллагын тусламж	513,987,832.86	378,953,817.53
Урсгал тусламж	513,987,832.86	378,953,817.53
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	6,436,379,677.14	8,898,111,741.16
Улсын төвлөрсөн төсвөөс	6,279,307,423.14	8,846,110,012.16
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,036,182,248.14	7,485,418,180.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	907,159,680.00	
Хөрөнгийн	335,965,495.00	183,858,028.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,176,833,804.16
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		143,502,935.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,030,086,369.16
Төсвийн урамшуулал		3,244,500.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	157,072,254.00	5,465,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	157,072,254.00	
Хөрөнгийн		5,465,000.00
Нийгмийн даатгалын сангаас		46,536,729.00
НДС-ийн шилжүүлэг		46,536,729.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	437,582,404.36	772,078,880.92
Бараа, үйлчилгээний борлуулалт	437,582,404.36	772,078,880.92
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	28,079,429.36	17,016,771.31
үндсэн бус үйл ажиллагааны орлого	28,079,429.36	17,016,771.31
Захиргааны хураамж	409,502,975.00	755,062,109.61
Шүүхийн шийдвэрийн төлбөр	409,502,975.00	755,062,109.61
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,599,586,478.06	10,672,418,046.40
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	2,724,033,447.70	3,157,269,020.10
үндсэн болон нэмэгдэл цалин	2,452,586,813.26	2,847,547,095.25
үндсэн цалин	1,619,070,208.36	2,417,259,865.25
Гэрээт ажилчдын цалин	565,613,930.20	
Бусад нэмэгдлүүд	267,902,674.70	430,287,230.00
үр дүнгийн урамшуулал	87,324,001.00	257,786,179.00
Унаа, болон бусад нөхөн олговор	180,578,673.70	172,501,051.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	271,446,634.44	309,721,924.85
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	223,070,140.30	254,009,783.79
Тэтгэврийн даатгалын шимтгэл	174,256,576.89	198,103,281.75
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,372,162.12	21,775,180.49

ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	24,501,195.08	27,872,331.53
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	11,940,206.21	6,258,990.02
Эрүүл мэндийн даатгалын хураамж	48,376,494.14	55,712,141.06
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,999,307,453.04</b>	<b>5,624,030,071.09</b>
Бараа үйлчилгээний урсгал зардал	1,923,998,994.00	4,786,742,880.69
Бусад бараа үйлчилгээний зардал	1,923,998,994.00	4,786,742,880.69
Бичиг хэргийн зардал	24,131,897.00	33,955,922.20
Тээвэр, шатахуун	61,802,607.85	287,374,266.00
Шуудан, харилцаа холбоо	57,300,952.95	57,188,635.60
Дотоод албан томилолт	40,729,854.00	429,795,796.00
Гадаад албан томилолт	12,427,346.00	52,347,361.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	24,000.00	50,000.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		18,089,146.00
Сургалт семинарын зардал	24,464,965.00	21,241,441.00
Эрдэм шинжилгээний ажил хийх	1,413,305,467.00	2,710,492,764.41
Төлбөр хураамж, жижиг татварууд	235,746,115.20	904,957,531.14
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,800,000.00	82,142,530.34
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		73,651,710.00
ТӨГАҮ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод) \		6,490,820.34
ТӨГАҮ \Эд хөрөнгийн даатгал\	2,000,000.00	
ТӨГАҮ \Тээврийн хэрэгслийн даатгал\	800,000.00	2,000,000.00
Маягт хэвлүүлэх зардал	4,275,000.00	36,110,660.00
Урсгал засвар	7,217,423.00	14,934,822.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		
Гадаадын зочны зардал	16,273,758.00	4,043,805.00
Засварын зардал		118,643,200.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	1,260,408.00	13,775,000.00
Байрны түрээс		1,600,000.00
Улсын мэдээллийн маягтын зардал	22,239,200.00	
Хөтөлбөр арга хэмжээний зардал	3,075,308,459.04	837,287,190.40
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	1,764,087,572.04	33,166,100.00
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	8,806,500.00	29,921,600.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	1,675,579,533.24	
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	79,701,538.80	3,244,500.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	1,311,220,887.00	804,121,090.40
Бусад төсөл арга хэмжээ	1,311,220,887.00	804,121,090.40
<b>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>481,180,824.97</b>	<b>1,175,965,121.20</b>
Олон улсын гишүүний татвар, хандив	13,904,800.00	14,948,850.00
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	467,276,024.97	1,161,016,271.20
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	467,276,024.97	1,161,016,271.20
Төвлөрүүлэх шилжүүлэг	467,276,024.97	1,161,016,271.20
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>174,510,022.00</b>	<b>200,010,188.00</b>
Нийгмийн даатгалын зардал	146,882,394.00	173,643,697.00
Нийгмийн даатгалын зардал	146,882,394.00	127,106,968.00
өндөр настны тэтгэвэр	146,882,394.00	127,106,968.00
Тэтгэмжийн даатгалын сан		46,536,729.00

Жирэмсний, амаржсаны эхийн тэтгэмж		46,536,729.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	27,627,628.00	26,366,491.00
Нэг удаагийн тэтгэмж	27,627,628.00	26,366,491.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	8,379,031,747.71	10,157,274,400.39
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	220,554,730.35	515,143,646.01
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	611,291,035.00	289,672,634.04
Хөрөнгийн бусад зардал	(69,400,000.00)	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	541,891,035.00	289,672,634.04
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(541,891,035.00)	(289,672,634.04)
Гадаад валютын ханшийн зөрүү		33,481,911.96
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		33,481,911.96
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(321,336,304.65)	258,952,923.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	394,302,580.17	72,966,275.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,966,275.52	331,919,199.45

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,141,865,972.73	39,572,394.04	(215,182,940.62)	1,966,255,426.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(5,720,908,134.21)	(5,720,908,134.21)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,141,865,972.73	39,572,394.04	(5,936,091,074.83)	(3,754,652,708.06)
үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	2,313,065,913.46	29,286,545.66		2,342,352,459.12
Тайлант үеийн үр дүн			(520,414,177.29)	(520,414,177.29)
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,317,089,247.17	39,122,026.98	(737,228,742.60)	1,618,982,531.55
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,317,089,248.17	39,122,026.98	(737,228,743.60)	1,618,982,531.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			293,195,357.79	293,195,357.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,317,089,248.17	39,122,026.98	(444,033,385.81)	1,912,177,889.34
үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(11,799,442.00)		(11,799,442.00)
үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(307,529,130.29)			(307,529,130.29)
Тайлант үеийн үр дүн			847,340,094.32	847,340,094.32
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,009,560,117.88	27,322,584.98	403,306,708.51	2,440,189,411.37

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ ДҮН			
	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,915,502,100.00	7,027,339,806.80	1,888,162,293.20	78.8
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	8,915,502,100.00	7,027,339,806.80	1,888,162,293.20	78.8
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	8,684,502,100.00	6,843,481,778.80	1,841,020,321.20	78.8
Бараа, үйлчилгээний зардал	8,474,093,100.00	6,676,059,469.80	1,798,033,630.20	78.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,838,171,200.00	2,788,114,761.25	50,056,438.75	98.2
Үндсэн цалин	2,344,783,600.00	2,357,827,531.25	(13,043,931.25)	100.6
Унаа хоолны хөнгөлөлт	180,190,900.00	172,501,051.00	7,689,849.00	95.7
Үр дүнгийн урамшуулал	313,196,700.00	257,786,179.00	55,410,521.00	82.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	315,186,200.00	307,672,776.85	7,513,423.15	97.6
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	257,879,500.00	251,960,635.79	5,918,864.21	97.7
Тэтгэврийн даатгал	200,572,700.00	196,054,133.75	4,518,566.25	97.7
Тэтгэмжийн даатгал	22,923,400.00	21,775,180.49	1,148,219.51	95.0
ҮОМШӨ ний даатгал	28,653,200.00	27,872,331.53	780,868.47	97.3
Ажилгүйдлийн даатгал	5,730,200.00	6,258,990.02	(528,790.02)	109.2
Эрүүл мэндийн даатгалын хураамж	57,306,700.00	55,712,141.06	1,594,558.94	97.2
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	57,306,700.00	55,712,141.06	1,594,558.94	97.2
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	5,320,735,700.00	3,580,271,931.70	1,740,463,768.30	67.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	5,320,735,700.00	3,580,271,931.70	1,740,463,768.30	67.3
Бичиг хэрэг	27,583,900.00	25,933,947.20	1,649,952.80	94.0
Тээвэр (шатахуун)	68,471,600.00	56,731,170.00	11,740,430.00	82.9
Шуудан холбоо	62,889,600.00	50,954,135.60	11,935,464.40	81.0
Дотоод албан томилолт	39,624,800.00	27,508,148.00	12,116,652.00	69.4
Гадаад томилолт /арга хэмжээ/	22,517,600.00	25,268,719.00	(2,751,119.00)	112.2
Ном хэвлэл авах	50,000.00	50,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,594,900.00	18,089,146.00	4,505,754.00	80.1
Сургалт, семинарын зардал	24,425,000.00	17,587,443.00	6,837,557.00	72.0
Эрдэм шинжилгээний ажил	4,279,551,100.00	2,569,389,296.87	1,710,161,803.13	60.0
Урсгал засвар	13,280,000.00	14,934,822.00	(1,654,822.00)	112.5
Төлбөр хураамж болон бусад зардал	501,374,600.00	521,738,968.69	(20,364,368.69)	104.1
Гадаад зочны зардал	3,161,400.00	4,043,805.00	(882,405.00)	127.9
Аж ахуйн материал худалдан авах зардал	13,775,000.00	13,775,000.00	-	100.0
Төвлөрсөн арга хэмжээ			-	
Орон нутгийн хувиарлагдаагүй зардал	133,701,500.00	122,203,200.00	11,498,300.00	91.4
Засварын зардал	129,426,500.00	118,643,200.00	10,783,300.00	91.7
Маягт хэвлэх зардал	4,275,000.00	3,560,000.00	715,000.00	83.3
Улсын мэдээллийн маягтын зардал			-	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж	76,052,900.00	82,142,530.34	(6,089,630.34)	108.0



Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	66,292,400.00	73,651,710.00	(7,359,310.00)	111.1
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод)	7,760,500.00	6,490,820.34	1,269,679.66	83.6
Тээврийн хэрэгслийн даатгал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Мэдээлэл сурталчилгааны зардал	31,681,800.00	29,921,600.00	1,760,200.00	94.4
Татаас ба урсгал шилжүүлэг	210,409,000.00	167,422,309.00	42,986,691.00	79.6
Өрх гэрт олгох шилжүүлэг	195,459,000.00	152,473,459.00	42,985,541.00	78.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал	167,537,300.00	127,106,968.00	40,430,332.00	75.9
Өндөр настны тэтгэвэр	167,537,300.00	127,106,968.00	40,430,332.00	75.9
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	27,921,700.00	25,366,491.00	2,555,209.00	90.8
Гадаад шилжүүлэг	14,950,000.00	14,948,850.00	1,150.00	100.0
Олон улсын байгууллагын гишүүний татвар	14,950,000.00	14,948,850.00	1,150.00	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>231,000,000.00</b>	<b>183,858,028.00</b>	<b>47,141,972.00</b>	<b>79.6</b>
1. Дотоод хөрөнгө оруулалт	231,000,000.00	183,858,028.00	47,141,972.00	79.6
Тоног төхөөрөмж : Төсвийн хөрөнгөөр санхүүжих	231,000,000.00	183,858,028.00	47,141,972.00	79.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>8,915,502,100.00</b>	<b>7,148,550,314.90</b>	<b>1,766,951,785.10</b>	<b>80.2</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,400,000.00	17,016,771.31	(2,616,771.31)	118.2
Гадаадын тусламжаас санхүүжих	378,672,600.00	623,273,606.79	(244,601,006.79)	164.6
Төсвөөс санхүүжих	8,522,429,500.00	6,508,259,936.80	2,014,169,563.20	76.4
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		72,966,275.52	(72,966,275.52)	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		265,904,379.29	(265,904,379.29)	
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>32.00</b>	<b>32.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>334.00</b>	<b>337.00</b>	<b>(3.00)</b>	<b>100.9</b>
Удирдах ажилтан	36.00	37.00	(1.00)	102.8
Гүйцэтгэх ажилтан	232.00	234.00	(2.00)	100.9
Гэрээт ажилтан	66.00	66.00	-	100.0